



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Соёл спортын ордны
2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДГА-2020/165/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

(Хотын нэр оруулах)

2019 он

Тэргүүлэх аудитор: Ч.Ариунаа

Утас: .70522734 Цахим хаяг: ariunaa.ch@audit.gov.mn

Аудитын менежерийн үүргийг

түр орлон гүйцэтгэгч Э.Энхцэцэг

Утас: 70523020 Цахим хаяг: enkhtsetseg@audit.gov.mn

Аудитор: Б.Отгон-Өлзий

Утас: 99844655 Цахим хаяг: shilenbalanceaudit@gmail.com

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Агуулга

1	Аудитын гэрчилгээ.....	3
2	Аудитын тайлан	5
2.1.	Оршил	5
2.2.	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3.	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	6
2.4.	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	6
2.5.	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	7
2.6.	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	7
2.7.	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	7
2.8.	Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	8
2.10.	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	9
2.11.	Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	10
2.12.	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	10
2.13.	Шилэн дансны мэдээлэл.....	10
2.14.	Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	11
	Дорноговь аймгийн Замын үүд сумын Соёл, спортын ордон 2019 оны 01 сараас эхлэн үйл ажиллагаа явуулж эхэлсэн тул 2018 онд санхүүгийн тайлангийн аудитад хамрагдаагүй болно.	11
2.15.	Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	11
3	Аудит хийсэн санхүүгийн тайлан	12

1 Аудитын гэрчилгээ



**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,
3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр,
Утас: (705) 2-27-34
Вэб сайт: dornogovi@audit.gov.mn

ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАМЫН-
ҮҮД СУМЫН СОЁЛ, СПОРТЫН
ОРДНЫ ДАРГА Г.БАТЗАЯА
ТАНАА

2020.02.28 № 1-6/184
танай _____ -ны № _____ -т

Аудитын гэрчилгээ

Монгол Улсын Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Соёл, спортын ордны 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Соёл, спортын ордны 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Соёл, спортын ордны 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагын хэмжээнд мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллага үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.АРИУНАА

2 Аудитын тайлан

2.1. Оршил

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Соёл спортын ордны 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг дарга Г.Батзаяа танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Соёл спортын ордны 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Соёл спортын ордны 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс 2020 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 01-ний өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Шилэн баланс Аудит ХХК-ийн аудитор Б.Отгон-Өлзий хариуцаж хэрэгжүүлэв.

Дорноговь аймгийн Замын үүд сумын Соёл, спортын ордон 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорноговь аймаг дахь төрийн аудитын газарт

2020 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр-ны өдрийн 08 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Соёл спортын ордны талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Дорноговь аймгийн Замын үүд сумын Соёл, спортын ордны эрхэм зорилго нь чанартай уран бүтээл туурвиж, соёлтой үйлчилгээг нэвтрүүлэн эелдэг харилцааг төлөвшүүлэх, нийгмийн эрүүл мэнд, нийтийн биеийн тамир спортыг хөгжүүлэх, иргэдийн биеийн тамирч, спортоор хичээллэх сонирхлыг нэмэгдүүлэх, оюун санаа бие бялдрын хөгжлийг хангах гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Засаг даргын 2018оны 12 сарын 22-ны өрийн А/411 дүгэр захиарамжаар Замын-Үүд сумын Соёл спортын ордны үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Орон нутагт соёл урлаг, биеийн тамир, спортыг хөгжүүлэх
- Номын сангийн үйл ажиллагаа

Байгууллагын төсвийн захирагч нь Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль бусад холбогдох эрх зүйн актуудын хүрээнд үйл ажиллагаагаа явуулж байна.

Тайлант онд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хууль, тогтоомж түүнд нийцүүлэн гаргасан журам зааварт өөрчлөлт ороогүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан.

Тус Дорноговь аймгийн Замын үүд сумын Соёл, спортын ордны мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Дорноговь аймгийн Замын үүд сумын Соёл, спортын ордны нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд Санхүүгийн тооцоолох групп ХХК-ний "Acolous" программ хангамж ашигладаг байна.

Дорноговь аймгийн Замын үүд сумын соёл, спортын ордны дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн, гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Дорноговь аймгийн Замын үүд сумын Соёл, спортын ордны бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд 43 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож эрсдэлийн түвшинг их гэж үнэлэн 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 263,858.4 мянган төгрөгөөс тооцон 2,638.6 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Дорноговь аймгийн Замын үүд сумын Соёл, спортын ордны 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 2,831,409.6 мянган төгрөг байна.

Тус ордон 2019 онд байгуулагдсанаар дараахь хөрөнгө, хөрөнгийн эх үүсвэртэй болжээ.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага		22.9	22.9
Урьдчилгаа			
Бараа материал		30,138.0	30,138.0
Үндсэн хөрөнгө		2,841,734.5	2,841,734.5
Нийт хөрөнгө		2,831,409.6	2,831,409.6
Өр төлбөр			
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/		2,831,409.6	2,831,409.6
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн		2,831,409.6	2,831,409.6

Авлага дансны үлдэгдэл 22.9 мянган төгрөг нь Нийгмийн даатгалын хэлтсээс авах хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмжийн авлага байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 30,138.0 мянган төгрөгийн бараа материалыг ангиллаар авч үзэхэд тусгай зориулалтын материал 5,633.2 мянган төгрөг, бичиг хэргийн материал 94.9 мянган төгрөг, аж ахуйн материал 24,283.9 мянган төгрөг, түлш, шатах тослох материал 79.0 мянган төгрөг, бусад хангамжийн материал 46.9 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна

Тайлант онд нийт 41,847.3 мянган төгрөгийн бараа материалын бэлтгэсний 15,350.2 мянган төгрөгийг төсвийн хөрөнгөөр худалдан авсан, 4,495.4 мянган төгрөгийг хандиваар, 4,929.7 мянган төгрөгийг шилжүүлэн авсан, 16,772.0 мянган төгрөгийг бусад эх үүсвэрээр бэлтгэн 11,709.3 мянган төгрөгийг зарцуулж 30,138.0 мянган төгрөгийн бараа материалын үлдэгдэлтэй ажилласан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2,841,734.5 мянган төгрөг байна. Нийт хөрөнгийн 2,812,121.2 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй буюу орон нутгийн хөрөнгө оруулалтаар 16,670.5 мянган төгрөгийг шилжүүлэн авсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 2,831,409.6 мянган төгрөг болсон нь хөрөнгө энэ хэмжээгээр бэлтгэгдэж тайлант онд 2,831,409.6 мянган төгрөг ашигтай ажилласантай холбоотой байна.

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуульд зааснаар Дорноговь аймгийн Замын үүд сумын Соёл, спортын ордон тайлант онд орлого төвлөрүүлэх төлөвлөгөө батлагдаагүй боловч үйл ажиллагаа 2019 оны 01 сарын 02-ны өдрөөс явуулж үндсэн үйл ажиллагааны хүрээнд 31,222.2 мянган төгрөгийн, хандиваар 5,000.0 мянган төгрөгийг нийт 36,222.2 орлогыг дансандаа төвлөрүүлэн зарцуулсан байна.

Хүснэгт 2. Төвлөрүүлэх орло

/мянган төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Биеийн тамирын заалын түрээсийн орлого		15,069.2	15,069.2	
Соёлын ордны заалын түрээс орлого буюу тоглолтын орлого		16,153.0	16,153.0	
Нийт дүн		31,222.2	31,222.2	

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрт зориулан 218,599.8. мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 218,599.8 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 218,599.8. мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Урсгал зардлын гүйцэтгэлийг төлөвлөлттэй зэрэгцүүлсэн судалгаа Үүнд:

/мянган төгрөг/

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	61,381.2	60,539.3	-841.9	98.6
2	НДШ-ийн зардал	7,753.4	7,623.7	-129.7	100.0
3	Гэрэл, цахилгаан	6,623.4	5,975.1	-648.3	95.1
4	Түлш, халаалт	115,865.8	115,703.1	-162.7	100.0
5	Цэвэр, бохир ус	3,204.7	2,833.8	-370.9	89.1
6	Бичиг хэрэг	63.0	86.0	23.0	100.0
7	Тээвэр, шатахуун	79.7	79.0	-0.7	100.0
8	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	65.1	63.0	-2.1	99.7
9	Ном хэвлэл	62.8	39.8	-23.0	33.3

10	БҮТЭЭ	500.4	221.7	-278.7	96.7
11	Нормын хувцас зөөлөн эдлэл	46.9	46.9	0.0	96.7
12	Урсгал засвар	20,700.0	17,736.7	-2,963.3	96.0
13	Албан томилолт	96.4	70.0	-26.4	97.0
14	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр	1,857.0	1,800.2	-56.8	91.7
15	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	300.0	300.0	0.0	68.0
	Нийт зардлын дүн	218,599.8	213,118.3	-5,481.5	97.5

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 213,118.3 мянган төгрөг буюу 97.5 хувьтай байгаа нь нийт 15 нэрийн зардлыг дүнгээр нь 5,481.5 мянган төгрөгөөр хэмнэсэнтэй холбоотой байна.

Нэмэлт төсөв: Хандив тусламжаар Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨҮГазраас 5,000.0 мянган төгрөг авсан, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 31,222.2 мянган төгрөг нийт 36,222.2 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс Цалин хөлсний зардалд 15,163.6 мянган төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлд 1,721.9 мянган төгрөг, багаж хэрэгсэл худалдан авахад 17,035.1 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөрт 2,138.8 мянган төгрөг, нийт 36,059.4 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 162.8 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 2, гүйцэтгэх үе шатанд 0 эрсдэл тодорхойлж нийт 2 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар алдаа зөрчил илрээгүй болно.

2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Дорноговь аймгийн Замын үүд сумын Соёл, спортын ордны 2019 оны үндсэн хөрөнгийн үлдэгдэлтэй түүвэрчилсэн тооллого явуулсан алдаа зөрчил илрээгүй боловч дараагийн аудитаар 2019 онд шинээр бэлтгэсэн үндсэн болон эргэлтийн хөрөнгөнд биет тест /тооллого/ хийх хэрэгтэй гэж үзэж байна.

2.13. Шилэн дансны мэдээлэл

Дорноговь аймгийн Замын үүд сумын Соёл, спортын ордон Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 137 мэдээллийг хугацаанд нь, 11 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Дорноговь аймгийн Замын үүд сумын Соёл, спортын ордон 2019 оны 01 сараас эхлэн үйл ажиллагаа явуулж эхэлсэн тул 2018 онд санхүүгийн тайлангийн аудитад хамрагдаагүй болно.

2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Дорноговь аймгийн Замын үүд сумын Соёл, спортын ордны 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Дорноговь аймгийн Замын үүд сумын Соёл, спортын ордны 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3 дахь заалтын дагуу үнэн зөв илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

3 Аудит хийсэн санхүүгийн тайлан

3.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	00.00	30,160,961.00
33	АВЛАГА	00.00	22,955.00
335	Бусад авлага	00.00	22,955.00
3351	Байгууллагаас авах авлага	00.00	22,955.00
35	БАРАА МАТЕРИАЛ	00.00	30,138,006.00
351	Түүхий эд материал	00.00	5,633,240.00
35110	Тусгай зориулалттай материал	00.00	5,633,240.00
354	Хангамжийн материал	00.00	24,504,766.00
35410	Бичиг хэргийн материал	00.00	94,900.00
35420	Аж ахуйн материал	00.00	24,283,966.00
35440	Түлш, шатах тослох материал	00.00	79,000.00
35470	Бусад хангамжийн материал	00.00	46,900.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	00.00	2,801,248,612.86
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	00.00	2,801,248,612.86
392	Биет хөрөнгө	00.00	2,800,386,946.19
39201	Барилга, байгууламж, орон сууц	00.00	2,660,941,083.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	00.00	-4,047,994.40
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	00.00	113,533,173.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	00.00	-26,634,901.35
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	00.00	60,380,215.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	00.00	-8,584,629.06
39214	Бусад үндсэн хөрөнгө	00.00	6,000,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	00.00	-1,200,000.00
393	Биет бус хөрөнгө	00.00	861,666.67
39301	Програм хангамж	00.00	880,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	00.00	-18,333.33
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	00.00	2,831,409,573.86
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	00.00	2,831,409,573.86
51	Засгийн газрын хувь оролцоо	00.00	2,831,409,573.86
512	Хуримтлагдсан үр дүн	00.00	2,831,409,573.86
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	2,831,409,573.86
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	00.00	2,831,409,573.86

3.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	/Төгрөгөөр/	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	00.00	3,095,267,971.92
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	00.00	2,845,445,971.92
120	Нийтлэг татварын бус орлого	00.00	2,840,445,971.92
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	00.00	2,840,445,971.92
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	831,600.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	00.00	2,839,614,371.92
122	Тусламжийн орлого	00.00	5,000,000.00
122001	Хандив тусламж /дотоод/	00.00	5,000,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	00.00	249,822,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	00.00	31,222,200.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	31,222,200.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	00.00	218,599,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	00.00	218,599,800.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	00.00	260,190,561.06
21	УРСГАЛ ЗАРДАЛ	00.00	260,190,561.06
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	00.00	253,414,625.73
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	00.00	75,679,952.96
210101	Үндсэн цалин	00.00	71,372,921.96
210104	Урамшуулал	00.00	4,307,031.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	00.00	9,345,568.14
210201	Тэтгэврийн даатгал	00.00	5,956,616.63
210202	Тэтгэмжийн даатгал	00.00	1,166,269.51
210203	ҮОМШӨ-ний даатгал	00.00	592,634.00
210204	Ажилгүйдлийн даатгал	00.00	235,923.00
210205	Эрүүл мэндийн даатгал	00.00	1,394,125.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	00.00	124,511,994.57
210301	Гэрэл, цахилгаан	00.00	5,975,118.57
210302	Түлш, халаалт	00.00	115,703,064.00
210303	Цэвэр, бохир ус	00.00	2,833,812.00
2104	Хангамж, бараа материалын зардал	00.00	197,690.00
210401	Бичиг хэрэг	00.00	43,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	00.00	63,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	00.00	91,190.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	00.00	12,374,004.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	831,490.00
210604	Урсгал засвар	00.00	11,542,514.00
2107	Томилолт, зочны зардал	00.00	70,000.00

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Соёл, спортын ордны 2019 оны
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210702	Дотоод албан томилолт	00.00	70,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	00.00	3,562,800.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	00.00	3,562,800.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	27,672,616.06
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	00.00	27,672,616.06
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	00.00	6,775,935.33
2132	Бусад урсгал шилжүүлэг	00.00	300,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	300,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	6,475,935.33
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	6,475,935.33
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	00.00	2,835,077,410.86
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	00.00	3,667,837.00
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	00.00	3,667,837.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	00.00	-3,667,837.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	00.00	2,831,409,573.86

3.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	00.00	255,653,600.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	00.00	5,831,600.00
120	Нийтлэг татварын бус орлого	00.00	831,600.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	00.00	831,600.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	831,600.00
122	Тусламжийн орлого	00.00	5,000,000.00
122001	Хандив тусламж /дотоод/	00.00	5,000,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	00.00	249,822,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	00.00	31,222,200.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	31,222,200.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	00.00	218,599,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	00.00	218,599,800.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	00.00	242,710,780.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	00.00	242,710,780.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	00.00	235,934,844.67
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	00.00	75,702,907.96
210101	Үндсэн цалин	00.00	71,395,876.96
210104	Урамшуулал	00.00	4,307,031.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	00.00	9,345,568.14
210201	Тэтгэврийн даатгал	00.00	5,956,616.63
210202	Тэтгэмжийн даатгал	00.00	1,166,269.51
210203	ҮОМШӨ-ний даатгал	00.00	592,634.00
210204	Ажилгүйдлийн даатгал	00.00	235,923.00
210205	Эрүүл мэндийн даатгал	00.00	1,394,125.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	00.00	124,511,994.57
210301	Гэрэл, цахилгаан	00.00	5,975,118.57
210302	Түлш, халаалт	00.00	115,703,064.00
210303	Цэвэр, бохир ус	00.00	2,833,812.00
2104	Хангамж, бараа материалын зардал	00.00	489,490.00
210401	Бичиг хэрэг	00.00	86,000.00
210402	Тээвэр, шатахуун	00.00	79,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	00.00	63,000.00
210404	Ном, хэвлэл	00.00	39,800.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	00.00	221,690.00
2105	Нормативт зардал	00.00	46,900.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	46,900.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	00.00	21,828,984.00

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Соёл, спортын ордны 2019 оны
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	4,092,270.00
210604	Урсгал засвар	00.00	17,736,714.00
2107	Томилолт, зочны зардал	00.00	70,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	00.00	00.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	00.00	3,939,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	00.00	3,939,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	00.00	6,775,935.33
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	00.00	6,313,141.33
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	00.00	6,313,141.33
2132	Бусад урсгал шилжүүлэг	00.00	300,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	300,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	162,794.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	162,794.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	00.00	12,942,820.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	00.00	12,942,820.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	00.00	12,942,820.00
2200	Дотоод эх үүсвэрээр	00.00	12,942,820.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	00.00	12,942,820.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	00.00	-12,942,820.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

3.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	2,831,409,573.86	2,831,409,573.86
D09	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	2,831,409,573.86	2,831,409,573.86

3.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Дүн	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	218,599,800.00	219,431,400.00	831,600.00	100.38
21	УРСГАЛ ЗАРДАЛ	218,599,800.00	219,431,400.00	831,600.00	100.38
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	218,299,800.00	212,818,258.67	5,481,541.33	97.49
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	61,381,200.00	60,539,283.96	-841,916.04	98.63
210101	Үндсэн цалин	57,481,200.00	57,158,574.96	-322,625.04	99.44
210104	Урамшуулал	3,900,000.00	3,380,709.00	-519,291.00	86.68
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	7,753,400.00	7,623,676.14	-129,723.86	98.33
210201	Тэтгэврийн даатгал	5,298,200.00	4,764,587.63	-533,612.37	89.93
210202	Тэтгэмжийн даатгал	613,800.00	1,029,437.51	415,637.51	167.72
210203	ҮОМШӨ-ний даатгал	491,000.00	491,063.00	63.00	100.01
210204	Ажилгүйдлийн даатгал	122,800.00	209,414.00	86,614.00	170.53
210205	Эрүүл мэндийн даатгал	1,227,600.00	1,129,174.00	-98,426.00	91.98
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	125,693,900.00	124,511,994.57	1,181,905.43	99.06
210301	Гэрэл, цахилгаан	6,623,400.00	5,975,118.57	-648,281.43	90.21
210302	Түлш, халаалт	115,865,800.00	115,703,064.00	-162,736.00	99.86
210303	Цэвэр, бохир ус	3,204,700.00	2,833,812.00	-370,888.00	88.43
2104	Хангамж, бараа материалын зардал	771,000.00	489,490.00	-281,510.00	63.49
210401	Бичиг хэрэг	63,000.00	86,000.00	23,000.00	136.51
210402	Тээвэр, шатахуун	79,700.00	79,000.00	-700.00	99.12
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	65,100.00	63,000.00	-2,100.00	96.77
210404	Ном, хэвлэл	62,800.00	39,800.00	-23,000.00	63.38
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	500,400.00	221,690.00	-278,710.00	44.30
2105	Нормативт зардал	46,900.00	46,900.00	00.00	100.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	46,900.00	46,900.00	00.00	100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	20,700,000.00	17,736,714.00	2,963,286.00	85.68
210604	Урсгал засвар	20,700,000.00	17,736,714.00	2,963,286.00	85.68
2107	Томилолт, зочны	96,400.00	70,000.00	-26,400.00	72.61

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Соёл, спортын ордны 2019 оны
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

	зардал				
210702	Дотоод албан томилолт	96,400.00	70,000.00	-26,400.00	72.61
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,857,000.00	1,800,200.00	-56,800.00	96.94
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,857,000.00	1,800,200.00	-56,800.00	96.94
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	300000.00	6613141.33	6,313,141.33	2,204.38
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	00.00	6,313,141.33	6,313,141.33	#DIV/0!
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	00.00	6,313,141.33	6,313,141.33	#DIV/0!
2132	Бусад урсгал шилжүүлэг	300,000.00	300,000.00	00.00	100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	300,000.00	300,000.00	00.00	100.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	218,599,800.00	219,431,400.00	831,600.00	100.38
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	218,599,800.00	218,599,800.00	00.00	100.00
132001	Орон нутгийн төсвөөс	218,599,800.00	218,599,800.00	00.00	100.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	00.00	831,600.00	831,600.00	
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	831,600.00	831,600.00	
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	1,020.00	58,301.00	57,281.00	
620001	Удирдах ажилтан	555.00	7,878.00	7,323.00	
620002	Гүйцэтгэх ажилтан	455.00	4,545.00	4,090.00	
620003	Үйлчлэх ажилтан	10.00	45,878.00	45,868.00	

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Соёл, спортын ордны 2019 оны
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Дүн	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	36,060.2	36,222.2	-162.0	100.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	36,060.2	36,222.2	-162.0	100.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	36,060.2	36,222.2	0.1	100.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	15,164.4	15,163.6	0.1	100
210101	Үндсэн цалин	14,237.4	14,237.3		100
210104	Урамшуулал	927.0	926.3	0.1	99.9
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,721.9	1,721.9		100.0
210201	Тэтгэврийн даатгал	1,170.8	1,192.0	-21.1	101.8
210202	Тэтгэмжийн даатгал	137.8	136.8	0.1	99.3
210203	ҮОМШӨ-ний даатгал	110.2	101.6	8.6	92.2
210204	Ажилгүйдлийн даатгал	27.5	26.5	1.0	96.2
210205	Эрүүл мэндийн даатгал	275.5	264.9	10.6	96.2
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	17,035.1	17,035.1		100.0
210604	Багаж техник хэрэгсэл	17,035.1	17,035.1		100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,138.8	2,138.8		100.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,138.8	2,138.8		100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		162.8		
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг		162.8		
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг		162.8		
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	36,060.2	36,222.2	162.0	100.4
1320	ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ	5,000.0	5,000.0		100.0
132001	Хандив тусламж /дотоод/	5,000.0	5,000.0		100.0
120004	НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	31,060.2	31,222.2	162.0	100.5
1200042	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бийн болсон нэмэлт орлого	31,060.2	31,222.2	162.0	100.5